



# СОЁМБОМ ЭДЭЭ

ӨДӨР ТУТМЫН ЦАХИМ СОНИН

МОНГОЛ УЛСЫНХАА ТӨЛӨӨ ЗҮТГЭЭ

№72 /286/

2022.04.13

Цаг үе, үйл явдал

## ТОО БУС ЧАНАРТ АНХААРЧ АЖИЛЛАХ ХЭРЭГТЭЙГ ҮҮРЭГ БОЛГОВ



Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн санаачилгын дагуу Батлан хамгаалах салбарынхан "Нэг тэрбум мод" үндэсний хөдөлгөөнд нэгдээд байгаа. Өнгөрсөн оноос эхэлсэн тус ажлын явц, үр дүн

цаашид хийгдэх ажлыг тодотгохоор Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай өнөөдөр БХЯ-ны харьяа байгууллагын дарга нартай хуралдлаа. Хурлын эхэнд БХЯ-ны харьяа байгууллагын удирдлагууд "Тэрбум мод" хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн болон хийгдэж буй ажлаа танилцуулав.

Үүний дараа Батлан хамгаалахын дэд сайд Б.Баярмагнай удирдлагуудад доорх үүргийг өглөө. Үүнд, Байгууллага бүр ойр орчмоо хэрхэн зүлэгжүүлэх моджуулах тодорхой төлөвлөгөөтэй байж, дэвсгэр зургийг бодитоор хийх, дээрх ажлыг гүйцэтгэх алба хаагчдын сургалтад хамруулж мэргэшүүлэх. Товч бөгөөд тодорхой, бодит

ажил хэрэг болох төлөвлөгөө боловсруулахыг үргэлжлээ. Тэрээр цааш нь хэлэхдээ "Улс орон даяар хэрэгжиж байгаа "Тэрбум мод" үндэсний хөтөлбөрийг Батлан хамгаалах салбар манлайлан оролцож байгаа. Энэ эрчээ цаашид алдаж болохгүй. 2030 он гэхэд нийт 7 мянган га талбайд 22 сая мод, сөөг, бутлаг ургамал тарьж ургуулна гэсэн зорилго тавин ажиллаж байна. Хэдий ийм зорилготой ч тоо бус чанарт анхаарч ажиллахыг чухалчлах хэрэгтэй. Мод тарих энэхүү хөдөлгөөн экологийн тэнцвэрт байдлыг хангаж цөлжилтийг бууруулах үйл хэрэгт үнэтэй хувь нэмэр оруулна гэдэгт итгэлтэй байна" гэв.

## БНӨСУ-Д ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭСЭН ЦЭРГИЙН БАГУУДЫН ХЭЛЭЛЦҮҮЛЭГ БОЛОВ



ЗХЖШ-ын Ажиллагааны удирдлагын газар, Энхийг дэмжих ажиллагааны хэлтсээс санаачлан Монгол цэрэг энхийг дэмжих ажиллагаанд оролцож эхэлсний 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүлэх төлөвлөгөөнд "Түүх сургаж-судалгааны чиглэл"-д тусгасан заалтын дагуу Зэвсэгт хүчний цэргийн алба хаагчид, цэргийн багуудын үүрэг гүйцэтгэсэн ажиллагааны туршлага, сургажыг нэгтгэн дүгнэх, баримтжуулан үлдээх цуврал хэлэлцүүлгийг зохион байгуулсаар байна.

хамтын ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Ж.Молорболд, АУГ-ын Энхийг дэмжих хамтын ажиллагааны хэлтсийн дарга хурандаа Т.Буянбат, Зэвсэгт хүчний Агаарын цэргийн штабын дарга бригадын генерал Б.Эрдэнэбат, Тусгай хүчний цэргийн штабын



дарга хошууч генерал Л.Гансэлэм нарын хүндэт зочид болон энэхүү ажиллагаанд үүрэг гүйцэтгэсэн өмнөх 10 ээлжийн цэргийн багуудын удирдлага, төлөөлөл оролцлоо.

Энэ үеэр Монгол Улсын Зэвсэгт хүчний цэргийн багууд Бүгд Найрамдах Өмнөд Судан Улсад Нэгдсэн Үндэстний Байгууллагын энхийг дэмжих ажиллагаанд оролцож, үүргээ нэр төртэй гүйцэтгэсний ач холбогдол, цэргийн баг тус бүрийн удирдлага, зохион байгуулалт, үүрэг гүйцэтгэх үеийн онцлог, ололттой талууд болон туршлага, сургажын талаар хэлэлцэж, нэгдсэн дүгнэлтэд хүрсэн юм.

Хурандаа Б.ОТГОНБАЯР



## ХУУРАЙ ЗАМЫН ЦЭРГИЙН НЭГТГЭЛ, АНГИУДЫН ШТАБЫН ДАРГА НАРЫН ЦУГЛАРАЛТААР ...

Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн нэгтгэл, ангиудын захирагчийн нэгдүгээр орлогч, штабын дарга нарын цугларалт Хуурай замын цэргийн командлалд эхэллээ. Цугларалт "Зэвсэгт хүчний Хуурай замын цэргийн 2022 оны үйл ажиллагааны зорилго, зорилтыг ханган, үүрэг гүйцэтгэх чадварыг дээшлүүлэх" сэдвийн хүрээнд хоёр хоногийн туршид явагдана. Энэ удаагийн цугларалтаар олон төрлийн асуудлыг багцлан ярилцаж буй бөгөөд Хуурай замын цэргийн командлагч, хошууч генерал Б.Амгаланбаатар Хуурай замын цэргийн сүүлийн үеийн ололт амжилт, анхаарах асуудал болоод штабын бэлтгэлжилт, цэргийн сургалт бэлтгэл, бэлэн байдал, албаны нэр хүнд, сахилга харууллага, ёс зүй, хандлага, бүтээлч байдлыг дээшлүүлэхэд авч хэрэгжүүлж байгаа



замын цэргийн 2022 оны зорилго нь "Мэдлэг, дадлага, чадварт суурилан Хуурай замын цэргийн үүрэг гүйцэтгэх чадварыг нэмэгдүүлэх" бөгөөд энэ хүрээнд 4 зорилтыг хэрэгжүүлэн ажиллаж байгаа юм. Үүнд, Хуурай



арга хэмжээний талаар мэдээлэл өгч, хурлын үйл ажиллагаанд амжилт хүслээ. Үргэлжлүүлэн тус командлалын Удирдлага, төлөвлөлтийн хэлтсийнхэн Хуурай замын цэргийн бэлэн байдлыг хангах удирдлага, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилт, харьяа нэгтгэл, ангиудаас боловсруулах удирдлага, төлөвлөлтийн баримт бичиг, сургуулийн жилийн цэргийн сургалт бэлтгэлийг зохион байгуулахад штабын дарга нарын үүрэг, "Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, сахилга дэгжурмыг бэхжүүлэх зөвлөл"-ийн 2022 онд дэвшүүлсэн зорилго, түүнийг хэрэгжүүлэх арга зам зэрэг олон сэдвээр мэдээлэл хүргэж, харилцан ярилцаж байна.

Ташрамд онцлоход, Хуурай

замын цэргийг хөгжүүлэх бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг цэргийн захиргааны удирдлагаар хангана. Цэргийн сургалтыг мэдлэг, дадлага, чадвартай бие хүнийг төлөвшүүлэхэд чиглүүлэн явуулж, цэргийн алба, сахилга, дэг журмыг бэхжүүлэн, цэргийн хөдөлмөрийн аюулгүй байдлыг хангана. Төрийн үйлчилгээ бүх талын хангалтыг тасалдалгүй зохион байгуулж, цэргийн алба хаагчийн нийгмийн хамгаалал, алба хаах орчныг сайжруулна. Хуурай замын цэргийг улс орныг хөгжүүлэх бүтээн байгуулалт, байгаль, экологийн тэнцвэрт байдлыг хангахад оролцуулна гэсэн зорилтууд багтаж байгаа юм.

### ЦАГ АГААР

УЛААНБААТАР

Өдөр	Шөнө
1	-8

ӨМНӨД СУДАН

Өдөр	Шөнө
38	23

### ВАЛЮТЫН ХАНШ

ВАЛЮТ	АВАХ	ЗАРАХ
USD	3,170.00	3,190.0
EUR	3,510.0	3,550.0
CNY	507.00	509.00
RUB	35.80	36.80
JPY	27.00	27.80
KRW	2.63	2.67

### ЗУРХАЙ

2022.04.13 ЛХАГВА ГАРАГ /БИЛГИЙН ТООЛЛЫН 12/

ХАВРЫН АДАГ ХӨХ ЛУУ САРЫН НАЙМАН ЦАГААН МЭНГЭТЭЙ УЛААН БИЧ ӨДӨР

Үс засуулбал: Өвчин эмгэг ирнэ  
Наран ургах, шингэх: 06.07-19.38  
Барилдлага: Үхэх  
Шүтэн барилдлага: Тийн мэдэхүй  
Суудал: Үс

Энэ өдөр хулгана, луу жилтнээ аливаа үйлийг хийхэд эерэг сайн ба могой, морь жилтнээ сөрөг муу нөлөөтэй тул элдэв үйлд хянамгай хандаж, биеэ энхрийлүүштэй. Эл өдөр элдэв үйлд хянуур хандах хэрэгтэй ба ан, гөрөө хийх, мал, адгуус муулах, сан тавиулах, угаал үйлдэх, бүжиг наадам хийх, цэцэрлэг байгуулах, урлан бүтээхэд сайн. Хувцас эсгэх, шинэ хувцас өмсөх, зөвлөгөө хийх, сэтгэлд сэвтэй газар очиход муу.

Өдрийн сайн цаг нь хулгана, үхэр, луу, могой, хонь, нохой болой. Хол газар яваар одогсод зүүн зүгт мөрөө гаргавал зохистой. Үс шинээр үргээлгэх буюу засуулахад тохиромжгүй.



ХҮЧТЭЙ ДАРХЛАА, ХҮЧТЭЙ ХАМГААЛАЛТ

ДАРХЛАГАА ХЭРХЭН САЙЖРУУЛАХ ВЭ?



## МОНГОЛ УЛС ДАХЬ КОРОНАВИРУСИЙН МЭДЭЭ

ВАКЦИНЖУУЛАЛТ I ТУН 2,272,656 /69.9%/	ВАКЦИНЖУУЛАЛТ II ТУН 2,175,006 /66.9%/	ДАРХЛАА СЭРГЭЭХ ТУН 1,034,693 31,8% 117,553 /3,6%/
НИЙТ БАТЛАГДСАН 8441 +112	ХЭВТЭН ЭМЧЛҮҮЛЖ БУЙ 6	ЭДГЭРСЭН 8314

### КОРОНАВИРУС ДЭЛХИЙ ДАХИНД

Тохиолдол

Нийт: 501,179,009

Эдгэрсэн

Нийт: 451,359,862

Нас барсан

Нийт: 6,209,691

Цахим шууданд

“САНХҮҮГИЙН АЛБАНЫ ГОЛ ХҮЧ ЯВЛАА” ДУРСАМЖ УУЛЗАЛТ БОЛЛОО



Батлан хамгаалах яамны 111 жил, орчин цагийн Зэвсэгт хүчин үүсэн байгуулагдсаны 101 жилийн ойг тохиолдуулан “санхүүгийн албаны гол хүч нь явлаа” дурсамж уулзалт өчигдөр офицеруудын ордноо зохион байгуулагдлаа.

Дарга хурандаа Д.Ганбат, ТЗУГ-ын Хүний нөөцийн хэлтсийн дарга хурандаа Д.Содномдаржаа, ЗХЖШ-ын Санхүүгийн хэлтсийн дарга хурандаа Б.Бүрэнтөгс болон БХЯ, ЗХЖШ, Зэвсэгт хүчний анги байгууллагаас тэтгэвэртээ гарсан ахмад санхүүчид оролцлоо. “Санхүүгийн албаны гол хүч нь явлаа” дурсамж

уулзалтын үеэр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд одон медаль болон Батлан хамгаалахын сайдын тушаалаар салбарын шагналаар шагнагдсан ахмад санхүүчдийн шагналыг гардуулан өгч баяр дээр нь баяр нэмсэн үйл ажиллагаа боллоо. Идэр залуу насаа Батлан хамгаалах салбарын санхүүгийн албанд ажиллаж байсан ахмадууд ийнхүү нэг өдөр уулзалдан залуу нас, хамт олныхоо талаар хууч хөөрөн залууст ажил, амьдралынхаа туршлагаас хуваалцахын зэрэгцээ ЦДБЭЧ-ын уран бүтээлчдийн тоглолтын үзэж сонирхлоо.

“АХЛАГЧИЙН АЛБА-НЭГЭН ЗҮГТ”



Зэвсэгт хүчний 327 дугаар анги

Монгол Улсын Батлан хамгаалахын Сайдын 2022 оны А/88 дугаар тушаал “Ахлагчийг хөгжүүлэх хөтөлбөр-2024” хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн ахлагчийн зөвлөл, Хилийн цэргийн 0132 дугаар ангийн ахлагчийн зөвлөлөөс санаачлан Дорнод аймгийн төрийн цэргийн байгууллагуудын ахлагчийн бүрэлдэхүүний хамтын ажиллагааг хөгжүүлэх, туршлага солилцох, хэлэлцүүлэг явуулах, цаашид хамтран ажиллах чиглэл, уриалга гаргах зорилгоор сахилгын зөвлөгөөнийг 2022 оны 4 дүгээр сарын 8-ны өдөр зохион байгуулж явууллаа. Зөвлөгөөнд Зэвсэгт хүчний 327 дугаар анги, Хилийн цэргийн 0132 дугаар анги, Дорнод аймгийн Онцгой байдлын газар, Дорнод аймгийн тагнуулын газар, Дорнод аймгийн цагдаагийн газар, Дорнод аймгийн шүүхийн шийдвэр гүйцэтгэх алба, Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн 085 дугаар салбарын ахлагчийн бүрэлдэхүүний төлөөлөл нийт 50 гаруй ахлагч хамрагдлаа. Сахилгын зөвлөгөөний хөтөлбөрийн дагуу

“Зэвсэгт хүчний ахлагчийн бүрэлдэхүүний сахилга, хариуцлагыг дээшлүүлэхэд тулгамдсан асуудлууд” үндсэн илтгэлийг Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн ажиллагааны ахлагч, сургагч ахлагч Э.Эрдэнэцогт хүрэлцэн ирсэн бүрэлдэхүүнд илтгэж, танилцуулсан бол “Ахлагчийн бүрэлдэхүүний нийгмийн хамгааллын тулгамдсан асуудлууд” сэдвээр Хилийн цэргийн 0132 дугаар ангийн ахлагчийн зөвлөлийн дарга, ахлах ахлагч С.Соёл-Эрдэнэ, Зэвсэгт хүчний 085 дугаар тусгай салбар, Дорнод аймгийн цагдаагийн газар, Дорнод аймгийн ОБГ, Дорнод аймгийн ШШГГ-ын ахлагчийн зөвлөлийн үйл ажиллагааны чиглэлийн танилцуулга хийгдлээ. Мөн Цэргийн хүрээний “Цэргийн цагдаагийн тасаг”-ийн үйл ажиллагааны чиглэлийг тус тасгийн дарга хошууч Н.Шинэбаяр зөвлөгөөнд оролцогчдод танилцуулан, мэдээлэл өгсөн юм. Илтгэл, танилцуулгын дараагаар хэлэлцүүлэг өрнүүлсэн бөгөөд тус хэлэлцүүлгээс цэргийн хүрээний ахлагчийн бүрэлдэхүүн “Ахлагчийн алба-нэгэн зүгт” уриа гаргаж, цаашид хамтын

ажиллагаагаа уялдуулан Чойбалсан цэргийн хүрээний төрийн цэргийн байгууллагуудын ахлагчийн бүрэлдэхүүний сахилгын зөвлөгөөнийг зохион байгуулах, цаашлаад Зүүн бүсийн буюу Дорнод, Хэнтий, Сүхбаатар аймгийн төрийн цэргийн байгууллагуудын ахлагчийн бүрэлдэхүүний чуулга уулзалтыг 2 жилд нэг удаа хамтарч зохион байгуулахаар болов. Мөн ахлагчийн зөвлөлүүд хоорондын хамтын ажиллагааг нэмэгдүүлж, сахилга хариуцлага, дэг журмыг сайжруулах, харилцан туршлага солилцох, хүмүүнлэгийн болон нийгэмд хандсан ажил өрнүүлж, жил бүр 1-2 ахлагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэж, ахлагчийн зөвлөлүүд хамтарч ажиллах талаар санал нэгтэй хэлэлцлээ. Тус зөвлөгөөнийг зохион байгуулснаар ахлагчийн бүрэлдэхүүний хамтын ажиллагаа өргөжиж, сахилга хариуцлага дээшлүүлж, цаашид хамтран ажиллаж, байгууллага хоорондын харилцааг хөгжүүлэхэд ахлагчийн оролцоог нэмэгдүүлэх нөхцөлийг бүрдүүлсэн үр өгөөжтэй ажил боллоо.

Ахмад Д.ГАНБААТАР

СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА НАРТАЙ “ЦЭРГИЙН БЭЛТГЭЛ” СУРГАЛТЫГ ЯВУУЛАВ



сургуульд хамрагдав. “Дайчилгааг сумдад зохион байгуулах, дайчилгааны даалгаврын оногдуулалт нь” сэдвээр хэлэлцүүлэг явуулж, Мандал-Овоо сумын ЗДТГ-ын “Дайчилгааны зарлан мэдээлэлтийг төлөвлөсөн байдал” үзүүлэх хичээлүүд орохын зэрэгцээ үзсэн сэдвүүдийн хүрээнд “Булгийн дасгал”-ыг боловсруулав. Мөн сумын дайчилгааны төлөвлөгөөний оногдуулан

Өмнөговь аймгийн ЗДТГ-ын Цэргийн штаб

Батлан хамгаалахын сайдын Өмнөговь аймгийн Засаг даргатай 2022 онд хамтран ажиллах гэрээний 1.3 дахь заалтыг хэрэгжүүлэн Цэргийн штабын 2022 оны сургалтын нэгдсэн төлөвлөгөөний дагуу Засаг даргын Тамгын газрын дарга нарын “Цэргийн бэлтгэл” сургалтыг Батлан хамгаалах салбарын хууль тогтоомжийг орон нутагт хэрэгжүүлэх, дайчилгааны төлөвлөгөөг тодотгох, цэргийн бүртгэл судалгааг хөтлөн явуулах, байгууллага аж ахуй нэгж, иргэдийг даалгаваржуулах, орон нутгийн цэргийг зохион байгуулахад сумдын Тамгын газрын дарга нарт мэдлэг, дадлага олгох, тэдний ажилд дэмжлэг үзүүлэх сургалтын зохион байгууллаа.



“Говийн бүсийн цэргийн сургалтын төв”-д энэ сарын 8-11-ний өдрүүдэд явагдсан тус сургалтад Өмнөговь аймгийн 15 сумын ЗДТГ-ын дарга, цэрэг онцгой байдал хариуцсан мэргэжилтэн хамрагдсан бөгөөд хөтөлбөрийн дагуу хичээл

данслал, орон нутгийн цэргийн томилгоожуулалтыг дахин хийж чанар байдлын судалгааг гаргалаа. Энэ үеэр буудлагын анхны дасгал, ЯЦБМ-ны жолоодлогын дасгал тус тус боловсрууллаа. Дэд хурандаа Д.УЛАМБАЯР

“ЦОЛ БҮХЭН САЙХАН” ГАР БӨМБӨГИЙН ТЭМЦЭЭНД БИЕ БҮРЭЛДЭХҮҮН АМЖИЛТТАЙ ОРОЛЦЛОО



Зэвсэгт хүчний 065 дугаар анги

Ангийн бие бүрэлдэхүүний амралт чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэх, гар нийлэмжтэй ажиллагаа, нөхөрсөг хамт олон бүрдүүлэх, бие бүрэлдэхүүний бие бялдрыг хөгжүүлэх зорилгоор жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг “Цол бүхэн сайхан” гар бөмбөгийн тэмцээнийг 4 дүгээр сарын 11-ний өдөр амжилттай зохион явууллаа.



Тус тэмцээнд хурандаа, дэд хурандаа нар нэг баг болж хошууч, ахмад, ахлах дэслэгч, дэслэгч, ахлах ахлагч, ахлагч, дэд ахлагч, ахлагчийн албан тушаалд энгийнээр туршилтын хугацаанд ажиллаж байгаа бүрэлдэхүүнээс нэг баг оролцсон бол ҮБХИС-иас цэргийн мэргэжлийн дадлага хийж буй сонсогч нар дадлага удирдсан багшийн хамт баг бүрдүүлэн оролцлоо. Тэмцээнд нийт 10 баг тамирчид өрсөлдсөнөөс тэрүүн байрт дэд хурандаа Д.Энх-Амгалан ахлагчтай /хурандаа, дэд хурандаа/ баг тамирчид, дэд байрт дэд ахлагч Тэмүүжин ахлагчтай / дэд ахлагч/ нарын баг тамирчид, гутгаар байрт ахлагч Пүрэвхишиг ахлагчтай /ахлагч/ нарын баг тамирчид бусдыгаа хошуучилж ҮБХИС-ийн дадлагын сонсогч нар тусгай байранд тус тус шалгарлаа.

